

**ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ,  
ТЭДГЭЭРИЙГ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН БОЛОН ТУСГААГҮЙ САНАЛЫН ТОВЬЁГ**

| Д/д                 | Санал   | Тусгасан байдал.   |
|---------------------|---|--|
| I.Монгол Даатгал ХК |   |  |
| 1.                  | Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 3.2.2 дахь хэсэгт заасан “даатгалын зуучлагч” гэж брокер, даатгалын төлөөлөгч гэсэн дээр нэмж “банк даатгалын зуучлагч” гэж нэмж оруулах.<br>Уг төслийн “аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хэсгийн 1 дүгээр зүйлд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.3 дахь заалтын “даатгалын мэргэжлийн оролцогчийн” гэснийг “даатгалын брокер, банк даатгалын зуучлагчийн” гэж өөрчлөхөөр оруулсан боловч уг төслийн 3.2.2 дахь хэсэгт “банк даатгалын зуучлагч”- ийг орхигдуулсан байна. | Тийм. Төслийн 3.2.2-т ““даатгалын зуучлагч” гэж даатгалын брокер, даатгалын төлөөлөгч, банк-зуучлагч;” гэж тусгав. Дагалдан өөрчлөгдөх Аж ахуйн үйл ажиллагааны хуулийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд оруулах өөрчлөлтийн зөрүүтэйг засах.   |
| 2.                  | Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийн 17.2.2 дахь хэсэгт заасан “хэд хэдэн даатгагчийг төлөөлөх” гэсэн заалтыг хасах. Хэрэв энэхүү заалт нь заавал байх ёстой гэж үзвэл төлөөлөгчид олгох даатгалын компани бүрийн шимтгэлийн хувийг СЗХ-оос ижил байхаар тогтоо өгөх шаардлагатай.   | Үгүй. Хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь 2-3 даатгагчийг төлөөлнөн ажиллахаар журмаар зохицуулан хязгаарлах боломжтой.  |
| 3.                  | Даатгалын төлөөлөгчийн эрх олгох асуудлыг Даатгагчдын Холбоонд шилжүүлэх.   | Үгүй. Даатгалын тухай хуулийн төслийн 23.1-т “Даатгалын мэргэжлийн холбоо нь даатгалын мэргэжлийн сургалт явуулах, давтан сургах, зөвлөгөө өгөх болон Хорооноос зөвшөөрсөн бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Холбооноос сургалтыг хэрэгжүүлэх талаар хуульд тусгаад хэрэв Холбоо нь цаашид шаардлагыг хангасан нөхцөлд эрх олгох асуудлыг Хорооноос Холбоо руу шилжүүлэх бүрэн боломжтой. |
| 4.                  | Төлөөлөгчдийн орлогоос НДШ-ийг чөлөөлөх, сайн дурын болгох. Даатгалын салбарт 2021 оны эцсийн байдлаар 2,403 төлөөлөгч бүртгэлтэй ажиллаж байна. Салбар нь олон хүнийг орлоготой байлгаж, эдийн засагт чамгүй хувь нэмэр оруулж байна. Гэвч төлөөлөгчдийг орлогоос НДШ төлөх, байгууллагаас мөн НДШ төлөх нь даатгагч болон төлөөлөгч аль аль талдаа зардлыг нэмэгдүүлж байгаа юм. Салбарын хөгжлийг дэмжих үүднээс түр   | Үгүй. Хамааралгүй заалт. Энэхүү асуудлыг тусгайлан авч үзэх боломжтой. Хуулийн төсөлд оруулах боломжгүй.   |

|                                   |   |  |
|-----------------------------------|---|--|
|                                   | хугацаанд НДШ -ээс чөлөөлүүлэх, хувь хүн өөрөө хүсвэл сайн дураар тайлагнаж төлдөг болгон өөрчлөх саналтай байна.   |  |
| <b>II. Монголын Банкны Холбоо</b> |   |  |
| 1                                 | 3.2.4-т нэмэлтээр дараах хувилбарыг оруулж “даатгалын төлөөлөгч” гэсэн хэсгийг 3.2.5 болгох. Үүнд: “Банк даатгалын зуучлагч” гэж даатгуулагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, даатгуулагчийг даатгагчтай холбож өгөх, талуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, үүнийхээ төлөө хөлс авах эрхтэй, тусгай зөвшөөрөл бүхий арилжааны банкийг; | Тийм, шийдвэрлээгүй. Батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу банк даатгалын үйл ажиллагаа эрхлэх нь олон улсдаа Bancassurance гэж нэрлэгддэг бөгөөд ихэнх улс орнууд банкийг даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхээр зохицуулсан байдаг байна. Харин нэршлийн хувьд янз бүрээр нэрлэдэг бөгөөд гол нь банкны үйл ажиллагааг хууль журамдаа тодорхой заасан байна. Иймээс төлөөлөгч биш, брокер биш харин “банк-зуучлагч” гэж нэрлээд үйл ажиллагаанд нь хязгаарлалт тавих нь зүйтэй тул хуулийн төслийн 3.2.2-т “даатгалын зуучлагч” гэж даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгч;” гэж, холбогдох тодорхойлолт болон бусад зохицуулалтыг нэмж тусгав. Дагалдан өөрчлөгдөх Аж ахуйн үйл ажиллагааны хуулийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд оруулах өөрчлөлтийн зөрүүтэйг засах. Банк-зуучлагчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тавихдаа: 1. Даатгалын орлогын шимтгэлийн хувь хэмжээг тогтоох 2. Эрхлэх даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтоох |
| 2                                 | Нэмэлтээр 9.4 дүгээр заалт болгон дараах байдлаар оруулах. Үүнд: “Банк даатгалын зуучлагч” нь хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр Брокерын үйл ажиллагааг эрхэлнэ гэж оруулах.   | Үгүй. Энэхүү хэсэг нь брокерын үйл ажиллагаатай холбоотой тул тусгах боломжгүй.  |
| 3                                 | 28.4. Даатгалын брокерын үйл ажиллагааг дараах аж ахуйн нэгж эрхэлнэ. Үүнд:<br>28.4.1. Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй компани   | Үгүй. Зах зээлийн нөхцөл байдал байнгын хувьсан өөрчлөгдж байдаг тул ирээдүйд энд зааснаас өөр шинэ даатгалын  |

|   |  |  |
|---|--|--|
|   | 28.4.2. Арилжааны банк<br>28.4.3. Банк бус санхүүгийн байгууллага  | бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах суваг гарч ирэх тул ингэж бүр нэг бүрчлэн зааж тусгах нь оновчтой бус юм. Харин банк-зуучлагчийг шинээр тусгахтай холбоотойгоор төслийн 28 дугаар зүйл Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаанд холбогдох заалтууд тусгав.                                      |
| 4 | 5.2.6. Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор даатгалын зуучлагчийн дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журам, заавар аргачлал, /цаашид “даатгалын зуучлалын журам” гэх-/ыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь “Даатгалын журам” гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журамын нэг хэсэг гэж ойлгож болох тул саналыг тусгахгүй. |
| 5 | 6.1. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг энэ хууль болон Хорооноос баталсан даатгалын зуучлалын журмаар зохицуулна.   | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь “Даатгалын журам” гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журамын нэг хэсэг гэж ойлгож болох тул саналыг тусгахгүй. |
| 6 | 21.1. Даатгалын брокерын хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд даатгалын зуучлалд холбогдох журмыг Хороо батална.  | Тийм. 21.1. Даатгалын брокерын хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд даатгалын зуучлалд холбогдох журмыг Хороо батална.  |
| 7 | 7.2.3 Эрсдэлээ даатгалд шилжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, даатгалын хөтөлбөрийг санал болгох гэж нэмж оруулах  | Хэсэгчлэн тусгав. 7.2.3. даатгалын гэрээ байгуулахаас өмнө эрсдэлээ даатгалд шилжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, даатгалын бүтээгдэхүүн, даатгалын гэрээнд заасан даатгах эрсдэл, даатгалын үнэлгээ,  |

|   |   |   |
|---|---|---|
|   |   | хураамж, даатгалын нөхөн төлбөр хэрхэн авах, даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг даатгуулагчид энгийн ойлгомжтой түвшинд тайлбарлан өгөх;   |
| 8 | 11.7. Хороо тусгай зөвшөөрлийг олгосон, түдгэлзүүлсэн, цуцалсан тухай даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.  | Тийм. 11.7.Хороо тусгай зөвшөөрөл олгосон, түдгэлзүүлсэн, цуцалсан тухай даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.   |
| 9 | 14.2. Гадаадын даатгалын брокер нь тусгай зөвшөөрөлтэй дотоодын даатгалын брокертой гэрээ байгуулан хамтарч ажиллахаас бусад тохиолдолд аливаа этгээд гадаадын даатгалын брокерыг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. | Үгүй. Гадаад улсдаа даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөө аль хэдийн авчихсан компанийг Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар төлөөлөгчийн газраараа дамжуулан даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэхдээ зөвшөөрөл авах талаар зохицуулсан заалт тул хэвээр үлдээх. Харин дараах байдлаар илүү тодотгож өгөх саналтай байна. Үүнд:<br>14.1.Гадаадын даатгалын брокер нь гагцхүү Хорооноос авсан зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрхтэй.<br>14.2.Гадаадын даатгалын брокер нь энэ хуулийн 14.1-д заасны дагуу Хорооноос зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын даатгалын брокерыг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:<br>14.2.1.даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх;<br>14.2.2.даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах зорилгоор |

|    |   |   |
|----|---|---|
|    |   | <p>сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах; 14.2.3.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.</p> <p>14.3.Энэ хуулийн 14.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхийг хүсэж буй этгээд нь Хороонд хүсэлт гаргана.</p> <p>“OECD-ийн гишүүн улс орнууд, Азийн болон Төв, Зүүн Европын орнууд ба Аж үйлдвэрийн шинэ улс орнуудын даатгалын хяналт зохицуулалт”-д дурдсанаар Хонг Конг, Макао, Сингапур улсуудад зөвхөн давхар даатгалын үйл ажиллагаанд гадаадын брокерууд бизнес эрхэлж болдог байна. Харин Тайланд, ОХУ, Япон, Казакстан, Чех, Исланд улсуудад гадаадын брокеруудад заавал зөвшөөрөл олгосны, мэдэгдсэний, бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг бөгөөд зарим улс орон гадаадын даатгагч болон брокеруудыг орохыг зөвшөөрдөгүй байна.</p> |
| 10 | 28.2. Энэ хуулийн 14.2 болон 28.1 дэх заалт нь даатгалын зуучлагч нь гадаадын даатгагч болон гадаадын давхар даатгалын брокертой гэрээгээр хамтран ажиллахад хамаarahгүй. | Үгүй. Төслийн 14.2 дэх заалтын агуулга өөрчлөгдөөгүй тул энэ саналыг авах шаардлагагүй.   |
|    | 31 дүгээр зүйл. Мэргэжлийн зохистой үйл ажиллагааны ёс зүйн дүрэм   | Үгүй. Олон Улсын зохицуулагч байгууллагуудын холбооноос гаргасан Даатгалын суурь зарчим 19-т "Зах зээлийн зохистой үйл ажиллагаа" буюу "Conduct of Business"-ийн шаардлагыг тодорхойлсон байдаг бөгөөд үүнд даатгагч болон даатгалын зуучлагчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах   |

|    |   |  |
|----|---|--|
|    |   | шаардлага багтсан байдаг. Иймд Зах зээлийн зохистой үйл ажиллагаа гэдэгт мэргэжлийн үйл ажиллагааны асуудал багтас тул саналыг тусгах шаардлагагүй.  |
| 11 | Даатгалын зуучлагч нь ёс зүйтэй, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд Даатгалын зуучлалын мэргэжлийн холбоонд гишүүн байж тогтмол мэргэшил ёс зүйн сургалтад хамрагдана гэж нэмэх  | Үгүй. ДТХ-ын шинэчилсэн найруулгын төслийн 20.2.2-т заасны дагуу даатгалын зуучлагч эсхүл брокер нэгдэн Даатгалын мэргэжлийн холбоог байгуулах боломжтой. Тус хуулийн төслөөр даатгалын мэргэжлийн холбооны эрх, үүрэг, шаардлагыг тодорхой зааж өгсөн байгаа. Даатгалын зуучлагч нарыг холбоонд заавал нэгдэх талаар зохицуулалт оруулах нь тохиромжгүй. Сургалтын хувьд холбогдох журмаар шаардлагыг зохицуулсан байгаа.   |
| 12 | Хуулийн төслийн 29.2-т "Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хэлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно." гэснийг хасах. [Тайлбар: Хуулиар хувийн хэвшлийн орлогын хэмжээг тогтоох нь зуучлалын салбарын хөгжлийг боох сөрөг үр дагавартай. Даатгалын Орлогын Шимтгэлийг бууруулахад илүү оновчтой аргыг ашиглах боломжтой. Даатгалын тухай хуульд Даатгагч нь даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр хураамжийн орлогод ногдох борлуулалтын шимтгэлийн орлогын дээд хязгаарыг актуар тооцоололд тусгах бөгөөд уг хязгаарыг давж ДОШ олгосон тохиолдолд ДОШ хүлээн авсан даатгалын төлөөлөгч, брокер, ДОШ олгосон даатгагч энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ гэж Хяналт, хариуцлагын хэсэгт шинэ заалтаар зохицуулах боломжтой. | Үгүй. ДТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулна.", 8.2-т "Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг даатгагч тогтооно." гэж тус тус заасан. Хороо зөвхөн шаардлагатай тохиолдолд даатгалын хураамжийн тооцооллын нэг хэсэг болох даатгалын гэрээний зардал буюу даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хэлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, |

|   |  |  |
|---|--|--|
|   |  | хязгаарыг тооцоолох боломжийг байлгах үүднээс тус саналыг хүлээн авах боломжгүй.   |
| <b>III. Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо</b> |  |  |
| 1.  | Төслийн 3.2.3-ыг "... даатгалын гэрээ байгуулахад зуучлах, эрсдэлээ шилжүүлэхэд нь мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;" гэх  | Хэсэгчлэн тусгав. 3.2.3."даатгалын брокер" гэж даатгуулагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, даатгалын гэрээ байгуулахад зуучлах, даатгуулагчийг даатгагчтай холбож өгөх, талуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, үүнийхээ төлөө хөлс авах эрхтэй, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг; |
| 2.  | Төслийн 3.2.4 нь Даатгагч өөрөө Төлөөлөгчид эрх олгохоор ойлгогдож байна. Гэтэл 5.2.4 –т СЗХ төлөөлөгчид эрх олгох, хасах, үйл ажиллагаанд нь хяналт тавихаар оруулсан нь логик зөрчилтэй харагдаж байна. Эрх олгох гэдэг хэсгийг хаана эрх олгохыг нь тодорхой болгох. Мөн 17.2.2-т заасан хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч байхаар орсон байна. Тэхээр 17.2.2-т заасан төлөөлөгчийг хэд хэдэн даатгагч томилж, эрх олгоно гэсэн үг үү? | Тийм. 3.2.4."даатгалын төлөөлөгч" гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу Хорооноос эрх олгосон этгээдийг;   |
| 3.  | Төслийн 5.2.1-ийг "Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар даатгалын мэргэжлийн оролцогч байгууллагуудаас болон түүнийг төлөөлөх мэргэжлийн холбооноос санал авах, нэгтгэж санал боловсруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;" гэх   | Үгүй. Журам батлахад Захиргааны ерөнхий хуулийн дагуу санал авдаг.   |
| 4.  | Төслийн 5.2.2-ыг "Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар үүрэг, даалгавар өгөх, зөвлөх, чиглүүлэх, туслах, хариуцлага ногдуулах;" гэх   | Үгүй. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хувьд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авагдана, иймд зөрчлийн шинжтэйгээс бусад асуудалд журмын хэрэгжилтийг хангуулах үүрэг, даалгавар өгч ажилладаг. Шалгалтын зорилго нь өөрөө юу вэ, хуулийн хэрэгжилт хангуулах.   |
| 5.  | Төслийн 5.2.6-г "даатгалын зуучлалын журам" гэж холбогдох бусад заалтуудад тусгах, учир нь Энэ хуулиар даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохицуулж байгаа тул энэ хуулийн хүрээнд брокер, төлөөлөгчийн  | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь "Даатгалын журам" гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах  |

|    |  |   |
|----|--|---|
|    | дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журам, заавар, аргачлал бүхий тусдаа журамтай байх нь зүйтэй байна.  | бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журам-ын нэг хэсэг гэж ойлгож болох тул саналыг тусгахгүй.   |
| 6. | Төслийн 6.1-д заасныг "даатгалын зуучлалын журам" гэх  | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь "Даатгалын журам" гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журам-ын нэг хэсэг гэж ойлгож болох тул саналыг тусгахгүй.   |
| 7. | Төслийн 6.2-т заасныг "зуучлалын дараах журмаар батална." гэх  | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь "Даатгалын журам" гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журам-ын нэг хэсэг гэж ойлгож болох тул саналыг тусгахгүй.   |
| 8. | Төслийн 6.2.4-т заасан "гадаадын" гэхийг тайлбарлах  | Тийм. Дотоодын даатгалын брокерт тавигдах шаардлагыг "даатгалын зуучлагч, түүний үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-д тусгасан байдаг тул гадаадын даатгалын брокер нь МУ-д салбар төлөөлөгчийн газар нээхэд тусгайлан зохицуулсан журам байх шаардлагатай. 6.2.4.салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа явуулах гадаадын даатгалын брокерт тавигдах нөхцөл, шаардлага; |
| 9. | Төслийн 6.2.5-ыг "Даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг жигд тогтвортой хэвийн явуулахад нь туслах, чиглүүлэх, зөвлөх, хяналт, шалгалт хийх;" гэх | Үгүй. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хувьд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авагдана, иймд зөрчлийн  |

|     |   |  |
|-----|---|--|
|     |   | шинжтэйгээс бусад асуудалд журмын хэрэгжилтийг хангуулах үүрэг, даалгавар өгч ажилладаг. Шалгалтын зорилго нь өөрөө юу вэ, хуулийн хэрэгжилт хангуулах.  |
| 10. | <p>Төслийн 6 дугаар зүйлд "Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо" гэсэн зүйл нэмэх,</p> <p>6.1. Даатгалын брокерын тусгай зөвшөөрөл авсан этгээд нь Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо /цаашид "Холбоо" гэх/-нд заавал гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна;</p> <p>6.2. Холбоо нь даатгалын мэргэжлийн оролцогч байгууллагын хувьд түүний нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, зуучлагчийн эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх болон энэ хуулийн 6.3 дугаар бүлэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>6.3. Холбоо нь дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх алба, мэдээллийн сантай байна:</p> <p>6.3.1. Даатгалын мэргэжлийн оролцогч байгууллагуудын даатгалын үйл ажиллагаанд туслах, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн сан;</p> <p>6.3.2. даатгагч, даатгуулагч, иргэнээс даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийх, зөвлөх алба;</p> <p>6.3.3. Даатгалын мэргэжлийн оролцогч этгээдийн эрсдэлийн санг бүрдүүлэх.</p> <p>6.5. Холбоо нь дараах үндсэн эрх, үүрэгтэй:</p> <p>6.5.1. гишүүдийн үйл ажиллагааны уялдаа, холбоог хангах;</p> <p>6.5.2. гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах;</p> <p>6.5.3. шүүхийн өмнө гишүүдийн эрх ашгийг хамгаалах;</p> <p>6.5.4. даатгалын мэргэжлийн оролцогч нарт даатгалын сургалт, бүтээгдэхүүн танилцуулах сурталчилгаа явуулах.</p> <p>6.6. Холбооны хөрөнгө дараах үндсэн эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>6.6.1. үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;</p> <p>6.6.2. элсэлтийн хураамж, гишүүний татвар болон бусад төлбөр;</p> <p>6.6.3. зээл, тусламж, хандив;</p> <p>6.6.4. хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэр.</p> | Үгүй. Даатгалын тухай хуулийн төсөлд мэргэжлийн холбоотой хамаарах заалтууд тусгагдсан бөгөөд энэхүү хуулийн 2.3-т "Даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна." гэж заасны дагуу Даатгалын тухай хуулиар зохицуулна. |

|     |   |  |
|-----|---|--|
|     | <p>6.7. Хороо нь Холбооны үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, зааврыг баталж, уг холбооны үйл ажиллагаанд чиглэл өгөх, туслах, зөвлөх, хяналт тавина.</p> <p>6.8. Холбоо нь үйл ажиллагаагаа жил бүр Зохицуулах хороонд тайлагнах бөгөөд холбооны санхүүгийн хураангуй тайланг жил бүрийн эхний улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.</p> <p>6.9. Холбоо нь даатгалын мэргэжлийн оролцогч нарт зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлж, үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж хэлэлцэх, сургалт явуулах багш нарын талаар санал өгөх, сургалтын явц үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, үргэлжилсэн сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг боловсруулж холбооны Зөвлөлөөр батлуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>6.10. Холбоо нь мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, даатгалын мэргэжлийн оролцогчийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх болон ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох, даатгалын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийх зэрэг ажлыг байнга зохион байгуулна.</p> |  |
| 11. | Төслийн 7.2.3-ыг "даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгалын бүтээгдэхүүн, даатгалын гэрээнд заасан даатгах эрсдэл, даатгалын үнэлгээ, хураамж, даатгалын нөхөн төлбөр хэрхэн авах, даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг даатгуулагчид энгийн ойлгомжтой түвшинд тайлбарлан өгөх, мэдээлэл авах нөхцөл боломжоор цахим болон бусад хэлбэрээр хангах, эрсдэлээ даатгалд шилжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө өгөх;" гэх   | Хэсэгчлэн тусгав. 7.2.3.даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгалын бүтээгдэхүүн, даатгалын гэрээнд заасан даатгах эрсдэл, даатгалын үнэлгээ, хураамж, даатгалын нөхөн төлбөр хэрхэн авах, даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг даатгуулагчид энгийн ойлгомжтой түвшинд тайлбарлан өгөх, мэдээлэл авах нөхцөл боломжоор цахим болон бусад хэлбэрээр хангах, даатгуулагчийн ашиг сонирхолд нийцсэн эрсдэлийг даатгасан байх; |
| 12. | Төслийн 7.3-ыг хасах, төслийн 17.2.2-т заасан заалтыг хасах саналтай холбоотой  | Үгүй. Хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь 2-3 даатгагчийг төлөөлөхөөр журмаар зохицуулах боломжтой.  |
| 13. | Төсөлд 8.3 заалт шинээр нэмэх, 8.3. Тусгай зөвшөөрөлгүй этгээд нь цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.  | Үгүй. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах   |

|     |  |  |
|-----|--|--|
|     |  | тухай бүрд зөвшөөрлийн асуудал яригдахгүй. Харин хэрэгжүүлж буй арга хэрэгслийн нарийн төвөгтэй байдал, онцлог цар хүрээнээс хамааран шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авах гэдэг шаардлагын оронд Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын баталсан Сэндбоксын зохицуулалтын орчинд турших шаардлагыг тавих боломжтой юм.  |
| 14. | Төслийн 9.2-ыг хасах, 9.2 - ийн 9.2.1, 9.2.2, 9.2.3.- ийг хуульд тусгахгүйгээр журмаар зохицуулах боломжтой зохицуулалт. Хуульд тусгах шаардлага үгүй. | Үгүй. Энэхүү хуулийн батлагдсан үзэл баримтлалд тусгагдсаны дагуу даатгалын брокерыг мэргэшүүлэх, төрөлжүүлэх шаардлагатай бөгөөд даатгалын журмаар нарийвчилсан зохицуулахаар тусгав.   |
| 15. | Төслийн 10.2-ыг "... даатгалын зуучлалын журамд, .... хавсаргаж хүргүүлнэ." гэх  | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь "Даатгалын журам" гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журамын нэг хэсэг гэж ойлгож болох тул саналыг тусгахгүй. Харин утга найруулгын өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгах боломжтой. 10.2.Хүсэлтэд эрхлэх үйл ажиллагааны ангиллыг зааж, Хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын журамд заасан баримт бичгийг хавсаргаж хүргүүлнэ. |
| 16. | Төслийн 10.3-ыг хасах, Хуульд тодорхой бичиг баримтыг зааж өгсөн болон журамд туссанаас өөр баримт бичиг шаардахгүй байх                               | Үгүй. Шаардлагатай тохиолдол гарах тул эрх зүйн орчныг үлдээх.   |
| 17. | Төслийн 11.1-д "даатгалын брокерын тусгай зөвшөөрлийг олгох" гэх   | Тийм. 11.1.Хороо дараах шаардлагыг хангасан хүсэлт гаргагчид даатгалын брокерын тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн ангиллаас хамааран нэмэлт шаардлага тавьж болно:  |

|     |  |   |
|-----|--|---|
| 18. | Төслийн 11.1.6-г хасах, Тодорхой бус заалт   | Тийм. 11.1.6.тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхээргүй бол.   |
| 19. | Төслийн 11.2-ын "хэдийд ч" гэснийг хасах   | Тийм. 11.2.Хороо даатгалын брокерын үйл ажиллагааны цар хүрээ, ангилал, төрлөөс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг өөрчлөн тогтоож болно.   |
| 20. | Төслийн 11.6-д заасан 45 хоногийг багасгаж 30 хоног болгох   | Тийм. 11.6.Хороо хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.   |
| 21. | Төслийн 11.7-г "... даатгалын зуучлалын журамд" гэх  | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь "Даатгалын журам" гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журам-ын нэг хэсэг гэж ойлгож болох тул саналыг тусгахгүй. |
| 22. | Төслийн 12.2-т заасан "хүчингүй болгосон даатгалын брокер" гэснийг "хүчингүй болгосон этгээд" гэх  | Тийм. 12.2.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон этгээд энэ хуулийн 12.1-д заасан даатгалын брокерын үйл ажиллагаа явуулах эрхгүй.  |
| 23. | Төслийн 13.2-т "Даатгалын брокерын тусгай зөвшөөрөлтэй компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан болон компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээдэд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгохгүй." гэж заасан нь Даатгалын брокер компанийн 10-аас бага хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч төлөөлөгчийн үйл ажиллагааг давхар эрхэлж болно гэсэн үг үү? | Үгүй. Даатгалын брокерын тусгай зөвшөөрөлтэй компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан болон компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд даатгалын төлөөлөгчөөр ажиллах боломжтой.   |
| 24. | Төслийн 13.4-ийг "Даатгагчийн ажилтан, эрх бүхий албан тушаалтанд даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, төлөөлөгчийн эрхийг олгохгүй бөгөөд уг этгээд нь даатгалын зуучлагчийн үйл  | Тийм. 13.4.Даатгагчийн ажилтан, эрх бүхий албан тушаалтанд даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, төлөөлөгчийн эрхийг   |

|     |   |  |
|-----|---|--|
|     | ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчийн ажилтан буюу эрх бүхий албан тушаалтан байж болохгүй." гэх  | олгохгүй бөгөөд уг этгээд нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчийн ажилтан буюу эрх бүхий албан тушаалтан байж болохгүй.   |
| 25. | Төслийн 14.2-ыг "Гадаадын даатгалын брокер нь энэ хуулийн 14.1-д заасны дагуу Хорооноос зөвшөөрөл аваагүй тохиолдолд хамтран ажиллах гэрээ бүхий тусгай зөвшөөрөлтэй даатгалын брокероос аливаа этгээд гадаадын даатгалын брокерыг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:" гэх | <p>Үгүй. Гадаад улсдаа даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө аль хэдийн авчихсан компанийг Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар төлөөлөгчийн газраараа дамжуулан даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэхдээ зөвшөөрөл авах талаар зохицуулсан заалт тул хэвээр үлдээх. Харин дараах байдлаар илүү тодотгож өгөх саналтай байна. Үүнд:</p> <p>14.1.Гадаадын даатгалын брокер нь гагцхүү Хорооноос авсан зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрхтэй.</p> <p>14.2.Гадаадын даатгалын брокер нь энэ хуулийн 14.1-д заасны дагуу Хорооноос зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын даатгалын брокерыг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>14.2.1.даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх;</p> <p>14.2.2.даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах;</p> <p>14.2.3.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.</p> |

|     |   |  |
|-----|---|--|
|     |   | <p>14.3. Энэ хуулийн 14.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхийг хүсэж буй этгээд нь Хороонд хүсэлт гаргана.</p> <p>“OECD-ийн гишүүн улс орнууд, Азийн болон Төв, Зүүн Европын орнууд ба Аж үйлдвэрийн шинэ улс орнуудын даатгалын хяналт зохицуулалт”-д дурдсанаар Хонг Конг, Макао, Сингапур улсуудад зөвхөн давхар даатгалын үйл ажиллагаанд гадаадын брокерууд бизнес эрхэлж болдог байна. Харин Тайланд, ОХУ, Япон, Казакстан, Чех, Исланд улсуудад гадаадын брокеруудад заавал зөвшөөрөл олгосны, мэдэгдсэний, бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг бөгөөд зарим улс орон гадаадын даатгагч болон брокеруудыг орохыг зөвшөөрдөггүй байна.</p> |
| 26. | Төслийн 15.3-ыг "даатгалын зуучлалын журмаар" гэх   | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь "Даатгалын журам" гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журам-ын нэг хэсэг гэж олижож болох тул саналыг тусгахгүй.  |
| 27. | Төслийн 17.2.2-ыг хасах, эсвэл Брокерыг ОДТ төлөөлөгчөөс ялгаатай, давуу нөхцөлийг сайн тодорхойлж өгөх. Ингэсэн тохиолдолд уг заалтыг хэвээр үлдээх саналтай. Хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь Даатгалын брокерын үйл ажиллагаанаас төдийлөн ялгаатай биш, ижил түвшний үйл ажиллагаа явуулах бөгөөд, түүнд тавигдах нөхцөл шаардлага Брокероос бага байх тул цаашид Брокерын тоо цөөрөх, улмаар Брокерын зах зээл хумигдах эрсдэлтэй гэж үзэж байна. | Үгүй. Хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь 2-3 даатгагчийг төлөөлөхөөр журмаар зохицуулах боломжтой.  |

|     |  |  |
|-----|--|--|
| 28. | Төслийн 17.3-ыг "... үйл ажиллагаа эрхлэх эрхийг иргэнд олгоно." гэх, 17.2.2-ыг байлгах тохиолдолд энэ заалтыг өөрчлөхгүй хэвээр үлдээх.   | Үгүй. Хэвээр үлдээв.   |
| 29. | Төслийн 17.4-т нэмэлтээр "Даатгалын мэргэжлийн оролцогч нь зөвхөн гуравдагч этгээдийг даатгалын гэрээг борлуулах, зуучлах бөгөөд өөрийн ашиг сонирхлыг даатгуулсан бол зуучлалын хөлс, шагнал авахыг хориглоно." гэх | Хэсэгчлэн тусгав. "Даатгалын зуучлагч нь зөвхөн гуравдагч этгээдийн даатгалын гэрээг борлуулах, зуучлах бөгөөд өөрийн ашиг сонирхлыг даатгуулсан бол зуучлалын хөлс, шагнал авахыг хориглоно."   |
| 30. | Төслийн 18.1-ийг "Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээд нь энэ хуулийн 17.1-д заасан эрх авах тухай хүсэлтийг даатгагчаар дамжуулан Хороонд гаргана." гэх, Даатгагч төлөөлөгчид эрх олгохгүй. | Хэсэгчлэн тусгав. 18.1.Даатгагчаас даатгалын төлөөлөгчөөр томилсон этгээд нь энэ хуулийн 17.1-д заасан эрх авах тухай хүсэлтийг даатгагчаар дамжуулан Хороонд гаргана.   |
| 31. | Төслийн 18.2-ыг "даатгалын зуучлалын журамд" гэх   | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь "Даатгалын журам" гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журам-ын нэг хэсэг гэж олгож болох тул саналыг тусгахгүй. |
| 32. | Төслийн 19.2.1-ийн "... хуулийн этгээд бол компанийн нэр" гэхийг хасах   | Үгүй. Холбогдох заалтыг хэвээр үлдээсэн тул энэ заалтыг өөрчлөх шаардлагагүй.  |
| 33. | Төслийн 21.1-д заасан "мөнгөн" гэх үгийг хасах.  | Үгүй. Хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах орлогын эх үүсвэр нь мөнгөн хөрөнгө байх шаардлагатай тул саналыг тусгах шаардлагагүй.  |
| 34. | Төслийн 28.1-ийг "Даатгалын зуучлагч Даатгалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй этгээдтэй хамтран даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоно." гэх,   | Тийм. 28.1.Даатгалын зуучлагч Даатгалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй этгээдтэй хамтран даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.  |
| 35. | Төслийн 28.2-ыг анхаарах, Энэ хуулийн 14.2 болон 28.1-дэх заалт нь даатгалын зуучлагч гадаадын даатгагчтай болон гадаадын давхар даатгалын брокертой хамтран ажиллахад хамаарахгүй.                                  | Үгүй. Төслийн 14.2 дэх заалтын агуулга өөрчлөгдөөгүй тул энэ саналыг авах шаардлагагүй.  |

|     |  |  |
|-----|--|--|
| 36. | <p>Төслийн 28.4-т нэмэлтээр "28.4. Даатгалын төлөөлөгчийн холбогдох мэдээллийг /аль даатгалын компанийн төлөөлөгч болох, овог нэр, борлуулалтын мэдээлэл, татвар төлсөн мэдээлэл/ Хорооны цахим хуудаст нээлттэйгээр тогтмол байршуулах" гэх, Ингэснээр даатгалын компаниуд ДОШ- той холбоотой мөнгө угаах, авлигатай холбоотой асуудал цэгцрэх болно.</p> | <p>Үгүй. Холбогдох журамд тусган зохицуулах боломжтой тул саналыг тусгах боломжгүй.</p>  |
| 37. | <p>Төслийн 29.2-ыг заавал даатгалын хувьд болгох, Төрөөс албан журмаар даатгах зохицуулалтын хүрээнд хороо хувь хэмжээг даатгагч болон даатгалын зуучлагч брокерын хоорондын үл ойлголцлыг арилгах зорилгоор оролцох эрх нээлттэй байх нь чухал юм.</p>  | <p>Үгүй. ДТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулна.", 8.2-т "Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг даатгагч тогтооно." гэж тус тус заасан. Хороо зөвхөн шаардлагатай тохиолдолд даатгалын хураамжийн тооцооллын нэг хэсэг болох даатгалын гэрээний зардал буюу даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тооцоолох боломжийг байлгах үүднээс тус саналыг хүлээн авах боломжгүй.</p> |
| 38. | <p>Төслийн 31.1-ийг "Даатгалын зуучлалын мэргэжлийн холбоо нь даатгалын зуучлагчийн дагаж мөрдвөл зохих мэргэжлийн ёс зүйн дүрэм гаргасан байна." гэх</p>  | <p>Тийм. 31.1. Даатгалын зуучлалын мэргэжлийн холбоо нь даатгалын зуучлагчийн дагаж мөрдвөл зохих мэргэжлийн ёс зүйн дүрэм гаргасан байна.</p>   |
| 39. | <p>Төслийн 31.5-д нэмэлтээр "31.5. Даатгалын зуучлагч нь ёс зүйтэй, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд Даатгалын зуучлалын мэргэжлийн</p>   | <p>Тийм. 31.5. Даатгалын зуучлагч нь ёс зүйтэй, мэргэжлийн үйл ажиллагаа</p>   |

|   |   |  |
|---|---|--|
|   | холбоонд гишүүн байж, тогтмол мэргэшил ёс зүйн сургалтад хамрагдана." Гэх   | эрхлэхэд Даатгалын зуучлалын мэргэжлийн холбоонд гишүүн байж, тогтмол мэргэшил ёс зүйн сургалтад хамрагдана.   |
| <b>IV. Коверхилл даатгалын зуучлагч</b> |   |  |
| 1.                                      | <p>"Даатгалын үнэлгээ ихтэй гэрээний хувьд нэг даатгагч дангаар даатгах боломжгүй тохиолдолд бусад даатгалын компанид хамтрах санал гаргахыг үүрэг болгох" гэснийг Үзэл баримтлааас хасах [Тайлбар: Энэхүү үзэл баримтлал нь даатгалын зуучлагчид ялгавартай хандсан, давхар даатгалын зуучлалын үйлчилгээ эрхлэгч даатгалын зуучлагчид үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулах үзэл баримтлал байна. Учир нь, (1) даатгагч өөрөө шууд давхар даатгалд байршуулалт хийж буй нөхцөлд өөрийн хариуцах хэсгээс давсан хэсгийг бусад даатгалд санал болгох үүрэг хүлээдэггүй. Тийнхүү үүрэг хүлээлгэх нөхцөлд даатгагч нь өөрийн үйлчлүүлэгчийг алдах, бизнесийн үйл ажиллагааны нууцлал алдагдахад хүрнэ. (2) Гэтэл давхар даатгалын байршуулалтыг даатгалын зуучлагч хийж буй нөхцөлд (даатгагчийг төлөөлж) бусад даатгагчид санал гаргах нь даатгалын зуучлагчийг сонирхлын зөрчилд оруулна. Учир нь, даатгалын зуучлагч нь энэ нөхцөлд өөрийн үйлчлүүлэгч-даатгагчийн ашиг сонирхолд үнэнч байх ёс зүйн үүрэгтэй. Гэтэл түүнийг харилцагчийг бусад даатгалд санал болгох, мэдээлэл задруулах нь энэхүү ёс зүйн шаардлагыг зөрчсөн хэрэг болно. Үүнтэй холбоотой даатгагчид даатгалын зуучлалаар дамжуулан давхар даатгал хийлгэхээс татгалзах эрсдэлтэй болно. Өөрөөр хэлбэл, энэхүү үзэл баримтлал бүхий төсөл батлагдах нөхцөлд даатгагчид давхар даатгалын зуучлалын үйлчилгээнээс татгалзах сөрөг үр дагавар үүсэхээр байна. Дотоодын даатгалын компаниудыг дэмжих нь зүй ёсны шаардлага байж болох ч түүнд хүрэх арга хэрэгсэл нь хууль ёсны бөгөөд зах зээлийн хууль, жам ёсонд харшилсан байж болохгүй билээ. Өөрөөр хэлбэл, төр өөрт олгогдсон татвар болон мөнгөний бодлогын хүрээнд эдийн засгийн зохицуулалтыг хийх бус механик байдлаар хязгаарлалт хийж болохгүй. Энэ нь хууль тогтоогчийн бодоогүй олон, далд сөрөг үр дагавруудыг авчирдаг билээ. Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1-т "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага-....д нийцсэн олон хэвшил бүхий засагтай байна" гэж заасан. Иймд бид олон улсын эдийн засгийн хандлага, зах зээлийн зарчимдаа нийцүүлэх шаардлагатай билээ. Даатгагчийг өөрийн бизнесээ заавал бусад даатгалын компанийтай буюу өрсөлдөгчтэйгөө</p> | Үгүй. Үзэл баримтлалд тусгасан энэхүү зохицуулалт нь хамтын даатгал хийх боломжийг олгосон зохицуулалт бөгөөд даатгагчид үүрэг болгох хэлбэрээр зохицуулалт ороогүй болно. |

|    |   |  |
|----|---|--|
|    | хуваахыг үүрэг болгох нь зах зээлийн зарчим, өрсөлдөөнийг хамгаалахад нийцэхгүй юм.]  |  |
| 2. | <p>Төслийн 14-р зүйл: Гадаадын даатгалын брокерын үйл ажиллагаатай холбоотой санал: Энэ хэсгийг Монгол улсын хуулийн нийтлэг үзэл баримтлал болох ялгаварлахгүй, эрх тэгш байх үзэл баримтлалд нийцүүлж өөрчлөх [Тайлбар: Монгол Улсын хуулийн этгээдийн нэгэн адил шаардлага хангаж, тэр журмаар зөвшөөрөл авна гэдэг үзэл баримтлал барих нь чухал юм. Энд тийм заалт алга. Иймд Хороо гадаадын брокер, дотоодын брокер гэсэн хоёр журам батлаад хоёр стандарт тогтоож буйгаас өөргүй байна. Дотоодын брокер Хорооноос тавьдаг олон дүрэм журам, шаардлагыг баримталж ажиллах үүрэг хүлээдэг бол Гадаадын брокерууд Монгол улсын нутаг дэвсгэрт байрлах эрсдэл, хөрөнгө, хариуцлага, амь нас, аливаа ашиг сонирхлыг зуучлан байршуулахдаа хорооноос ямар ч үүрэг даалгавар хүлээж, шаардлага баримталдаггүй. Энэ бол эрх тэгш өрсөлдөөнийг хязгаарлаж байна. Монголчууд нь зовж, баахан шаардлага хангаж байхад хажууд нь нэг Английн эсвэл Хонг-Конгийн, эсвэл Казакстаны, эсвэл Энэтхэгийн, Латвиин гэх мэт брокер Монгол улсын ямар ч дүрэм, журам, шаардлагад баригдахгүйгээр Монгол улсад орших эрсдэл, хөрөнгө, ашиг сонирхлыг чөлөөтэй зуучлан ажиллаж байна. Иймд уг төслийн 14-р зүйлийн үзэл баримтлалыг гадаад, дотоод гэж ялгаварлаж, улмаар эрх тэгш бус байдал үүсгэх нөхцөлтэй байгааг запруулах үүднээс аливаа этгээд гэж тэгшигэж өөрчлөх буюу 14.1-р заалтыг “аливаа этгээд нь гагцхүү Зохицуулах хорооноос авсан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Монгол улсад даатгал, давхар даатгалын брокерын үйл ажиллагаа явуулах эрхтэй” гэж өөрчлөх саналтай байна.]</p> | <p>Үгүй. 14 дүгээр зүйлд заасан асуудал нь Гадаадад даатгалын брокерын тусгай зөвшөөрөл авсан компани Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газар байгуулахтай холбоотой асуудал юм. Харин Гадаадын компанийн хувьд Монгол улсад даатгалын брокерын тусгай зөвшөөрөл авах асуудал бол бусад компанийтай ижил. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан тусгай зөвшөөрөл бүхий компанийдын хувьд ч мөн салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудал байдаг. Мөн Даатгалын журмын "6.2.4.салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа явуулах гадаадын даатгалын брокерт тавигдах нөхцөл, шаардлага"-аар гадаадын даатгалын брокер салбар, төлөөлөгчийн газраа нээх тохиолдолд тавих шаардлагыг тодорхойлооор тусгасан байгаа.</p> |
| 3. | <p>14.2-р заалтыг 14.1-т тусгаж буй саналтай нийцүүлж “Энэ хуулийн 14.1-т заасны дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 14.2.1 Монгол улсын нутаг дэвсгэрт байрлах эрсдэл, хөрөнгө, хариуцлага, амь нас, аливаа ашиг сонирхлыг зуучлан байршуулах даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх, 14.2.2 Монгол улсын нутаг дэвсгэрт байрлах эрсдэл, хөрөнгө, хариуцлага, амь нас, аливаа ашиг сонирхлыг даатгасан даатгалын гэрээг давхар даатгалд зуучлан байршуулах давхар даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх” гэж нэмж тодруулах саналтай байна. [Тайлбар: Даатгалын Тухай Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19.1-р хэсэгт “аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт буй хөрөнгө, амь нас, эрүүл</p>   | <p>Үгүй. Гадаад улсдаа даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө аль хэдийн авчихсан компанийг Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар төлөөлөгчийн газраараа дамжуулан даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэхдээ зөвшөөрөл авах талаар зохицуулсан заалт тул хэвээр үлдээх. Харин дараах байдлаар илүү тодотгож өгөх саналтай байна. Үүнд: 14.1.Гадаадын даатгалын брокер нь</p>  |

|   |  |
|---|--|
| <p>мэнд, хариуцлага, ашиг сонирхлыг гагцхүү энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулна” гэж тусгасан. Аливаа этгээд гагцхүү энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулна гэсэн нь эрх тэгш байх үзэл баримтлалд нийцсэн болохыг дотоодын этгээд, гадаадын этгээд гэж ялгаж томьёололгүй харин аливаа этгээд гэж томьёолсноос харагдаж байна. Энэхүү эрх тэгш байдлыг хангах, үл ялгаварлах зарчмыг баримталсан томьёолол нь Даатгалын Зуучлалын Тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 14-р зүйл: Гадаадын Даатгалын Брокерын Үйл ажиллагаа хэсэгт дэвшиүүлж буй бидний саналтай нийцэж байгааг онцлох хүсэлтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-т “Монгол Улсад .... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан. Мөн зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, ... арьсны өнгө, ... хөрөнгө чинээгээр .... нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан. Иймд зайлшгүй шаардлага байхгүй л бол хууль тогтоогч нь дотоод болон гадаадын хуулийн этгээдүүдэд эрх тэгш хандах учиртай юм. Олон улсад тогтсон хандлага бол дотоодын зах зээлээ хамгаалах ойлголт байдаг. Харин чөлөөт эдийн засгийн ойлголт, зах зээлийн онол нь түүнийг эсэргүүцэх бөгөөд ингэхдээ гадаадын бизнесүүдийн дотоодын бизнестэй эрх тэгш авч үзэхийг шаарддаг. Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд ч дотоодын компаниудтай ижил, эрх тэгш хандахыг шаарддаг. Харин дотоодын бизнесүүдээс илүү давуу тал олгох тухай ойлголт байдаггүй. Иймд гадаадын брокер компаниудад дотоодын компанийтай ижил эсвэл илүү хүнд шаардлага тавих тухай ойлголт байхаас бус илүү таатай орчинтой байлгах нь зарчмын бус зүйл юм. Түүнчлэн, даатгал, даатгалын зуучлалын дотоодын компаниуд хангалттай томорч амжаагүй байгаа. Энэ үед дотоодын компаниудаа хамгаалах бодлого барихгүй бол бид томорч чадахгүй, харин нэгэнтээ томорсон гадаадын компаниуд Монгол Улсын зах зээлийг богино хугацаанд амархан эзлэх, Монгол Улсын зах зээл нь цөөн тооны гаднын компаниудаас хараат болох эрсдэл үүснэ. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй, хараат бус байдалд харш байх юм. Өөрөөр хэлбэл, бид эдийн засгийн хараат бус, аюулгүй байдлаа бүрдүүлэхийн тулд даатгалын салбар мэт жижиг зах зээлийн хувьд дотоодын компаниудаа хамгаалах нь маш чухал юм.]</p> | <p>гагцхүү Хорооноос авсан зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрхтэй.</p> <p>14.2.Гадаадын даатгалын брокер нь энэ хуулийн 14.1-д заасны дагуу Хорооноос зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын даатгалын брокерыг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>14.2.1.даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх;</p> <p>14.2.2.даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах;</p> <p>14.2.3.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.</p> <p>14.3.Энэ хуулийн 14.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхийг хүсэж буй этгээд нь Хороонд хүсэлт гаргана.</p> <p>“OECD-ийн гишүүн улс орнууд, Азийн болон Төв, Зүүн Европын орнууд ба Аж үйлдвэрийн шинэ улс орнуудын даатгалын хяналт зохицуулалт”-д дурдсанаар Хонг Конг, Макао, Сингапур улсуудад зөвхөн давхар даатгалын үйл ажиллагаанд болон Хятадын Тайбэй улсад ихэвчлэн амь насны даатгалын үйл ажиллагаанд гадаадын брокериуд бизнэс эрхэлж болдог байна. Харин Тайланд, ОХУ, Япон, Казакстан, Чех, Исланд улсуудад гадаадын брокериудад заавал зөвшөөрөл олгосны, мэдэгдсэний,</p> |
|---|--|

|    |   |   |
|----|---|---|
|    |   | бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг бөгөөд зарим улс орон гадаадын даатгагч болон брокеруудыг орохыг зөвшөөрдөгүй байна.                                  |
| 4. | <p>Төслийн 2.3-т “Даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна” гэдгийг “Иргэний хуулийн дагуу зохицуулна” гэж өөрчлөх, эсвэл 2.3 дахь заалтыг тэр чигт нь хасах. [Тайлбар: Учир нь, Даатгалын тухай хууль бол даатгагчийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан хууль. Иймд үүнийг Зуучлалын харилцаанд хэрэглэх боломжгүй. Дээрх заалт хэвээр байвал хууль хэрэглээний хувьд маш тодорхой бус байдал үүснэ. Тухайлбал, Зуучлалын тухай хуульд заагаагүй болон Даатгалын тухай хуульд байгаа зохицуулалт болгон зуучлалын харилцаанд үйлчлэх мэт ойлгомжгүй байдал бий болно. Мөн Даатгалын тухай хуулийн төслийн 3.2-т брокерын асуудлыг Зуучлалын тухай хуулиар зохицуулах талаар бичсэн байна. Өөрөөр хэлбэл, Даатгалын тухай хууль нь зуучлалын харилцаанд үйлчлэхгүй тухай тэнд бичсэн байна. Тэгсэн мөртөө Зуучлалын тухай хуулийн 2.3-т дээрх байдлаар заах нь техникийн хувьд ч алдаатай юм.]</p>   | <p>Тийм. “2.3. Даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулах бөгөөд энэ хуульд зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.”</p> |
| 5. | <p>Төслийн 3.2.1-3.2.3 дахь заалтуудаар даатгалын төлөөлөгч болон брокерыг нарийн ялгаж салгаагүй байна. Мөн эдгээрийг хамтад нь зуучлалын үйл ажиллагаа гэж байгаа нь ойлгомжгүй, төөрөгдөл үүсгэхээр байна. [Тайлбар: Олон улсад тогтсон ойлголтоор бол төлөөлөгч нь зөвхөн даатгагчийг төлөөлж, түүний бүтээгдэхүүнийг борлуулах байдлаар оролцох (agent) бол зуучлагч нь даатгагч, даатгуулагч аль аль талыг нь төлөөлөх боломжтой, гол нь даатгуулагч талд ажилладгаараа ялгаатай билээ. Гэтэл бид эдгээрийг нийлүүлээд “зуучлал” гэдэг нэг сагсанд хийж.</p> <p>Төөрөгдөл үүсгэх тухай: Даатгалын төлөөлөгч нь ч Даатгалын зуучлагч гэх ойлголтод багтах тул хэрэглэгчид брокер болон төлөөлөгчийг ялгах боломжгүй болно. Тухайлбал, төлөөлөгчид нь өөрсдийгээ Англи хэлээр “broker” гэж нэрлэхэд л зуучлагчаас ялгаа үүсэхгүй болно. Хуулийн төслийн дагуу бол одоогийн зуучлалын компаниуд “даатгалын брокер” эсвэл “даатгалын зуучлагч” гэдэг нэр хэрэглэх нь. Гэтэл брокер гэдэг бол зуучлалын л гадаад нэршил шүү дээ.</p> <p>Төлөөлөгч, зуучлагчийг нэг сагсанд хийх биш харин ч ялгааг нь нарийн хуульчилж, өөр хоёр этгээд болохыг тодотгох учиртай юм.</p> | <p>Үгүй. Төслийн 3.2.2-т “даатгалын зуучлагч” гэж даатгалын брокер, даатгалын төлөөлөгч, банк-зуучлагч” гэж, холбогдох тодорхойлолтыг тус зүйлд нэмж тусгав.</p>                  |

|    |  |  |
|----|--|--|
|    | <p>Томъёоллын санал:</p> <p>“Төлөөлөгч” гэж даатгалыг төлөөлж, даатгагчаас олгосон эрхийн дагуу тухайн даатгалын бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах, холбоотой нэмэлт үйлчилгээг даатгагчийн өмнөөс эрхлэх этгээд</p> <p>“Даатгалын зуучлагч” гэж үйлчлүүлэгчийг төлөөлж даатгал эсвэл давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа хийх, зөвлөгөө өгөх, үнэ, нөхцөлийн саналыг даатгал эсвэл давхар даатгалын зах зээлтэй тохиролцоо хийх, даатгалын гэрээний үйл ажиллагаа, хэрэгжилтэд мэргэжлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, үүнийхээ төлөө хөлс авах эрхтэй, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг; Үйлчлүүлэгч гэж даатгуулагч эсвэл даатгагч байж болно.]</p> |  |
| 6. | <p>6 дугаар зүйлийн “Даатгалын журам” биш Даатгалын зуучлалын үйл ажиллагааны журам болгох нь зөв юм. [Тайлбар: Даатгалын зуучлалын харилцааг зохицуулах гэж байгаа билээ.]</p>  | Үгүй. Даатгалын салбарт мөрдөх журмыг бүхэлд нь “Даатгалын журам” гэж нэрлээд, даатгалын харилцааг ерөнхийд нь Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан журам, заавар аргачлал нь Даатгалын журамын нэг хэсэг гэж олйгож болох тул саналыг тусгахгүй.   |
| 7. | <p>Хуулийн төслийн 6.2 дахь заалтын “Даатгалын тухай хуулийн 14.2-т зааснаас гадна” гэдгийг хасах нь зөв юм. [Тайлбар: Тэгэхгүй бол Даатгалын тухай хуулийн 14.2-т заасан даатгалын журмууд нь зуучлалын харилцаанд нэгэн адил үйлчлэх мэт ойлгогдож байна. Зөв нь, Даатгагчид холбогдох журмыг Даатгалын тухай хуульд заах, Зуучлалд холбогдох журмыг Зуучлалын хуульд заах хэрэгтэй юм. Тэгэхгүй бол холион бантан, тодорхой бус байдал гарна. Тухайлбал, даатгагчид гэж гаргасан журам болгон нь зуучлагчид хамааралтай ч юм шиг ойлгомжгүй байдал үүснэ.]</p>  | Үгүй. Журмыг боловсруулж батлуулахдаа хэн мөрдөх вэ гэдэг талаар тодорхой тусгасан байдаг. Даатгагч, даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгч гээд бүгд л даатгалын зах зээлийн оролцогчид, эд эс нь. Иймд даатгалын харилцааг бүхэлд нь зохицуулах даатгалын журам гэж яваад, нийтлэг харилцааг зохицуулах журмууд нь даатгалын тухай хуульд, харин даатгалын зуучлалтай холбоотойгоор нэмэх шаардлагатай журмуудыг даатгалын зуучлалын тухай хуулиар нэмж тусгаж өгөх нь зүйтэй. |
| 8. | <p>Төслийн 6.3 дахь заалтыг хасах нь зүйтэй. [Тайлбар: Учир нь, юу болох нь мэдэгдэхгүй, маш ерөнхий байдлаар Хороонд эрх олгох заалт байна. Үндсэн хуульд зааснаар хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал эдлэх</p>   | Үгүй. Хэдийгээр Хороонд даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиг үүрэг байхгүй ч гэлээ өдөр өдрөөр өөрчлөгдж буй  |

|     |  |   |
|-----|--|---|
|     | <p>учиртай. УИХ тус эрхээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлж болно. Гэхдээ зөвхөн хуулиар шилжүүлэх, мөн шилжүүлж буй бүрэн эрх нь тодорхой хүрээ хязгаартай байх учиртай байдаг. Тэрнээс биш маш ерөнхий байдлаар эрх шилжвэл Үндсэн хуульд заасан хууль тогтоох эрх мэдлийг парламентад хадгалах зарчим зөрчигдэх болно. Төслийн энэ заалт тэр хэвээр батлагдвал Хороо энэ хүрээнд юу ч гэж журам гаргаж болохоор байна. Энэ бол маш ноцтой асуудал юм.]</p>  | <p>нөхцөл байдалтай холбоотойгоор зах зээлийг дэмжих, даатгуулагч, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтын журам гарах зайлшгүй шаардлага бий болж болно. ДТХ-ийн 15.1.Зохицуулах хорооноос даатгагчийн үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан журам гаргаж болно. гэх заалт байдаг бөгөөд уг заалтыг үндэслэн "Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам"-ыг баталсан байна.</p> |
| 9.  | <p>Төслийн 7.2.5 дахь заалтын “Даатгагч байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол” гэдгийг “даатгагч эсвэл даатгуулагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол” гэж өөрчлөх. [Тайлбар: Учир нь, зуучлагчийн үйлчлүүлэгч нь даатгуулагч ч байх боломжтой. Энэ нөхцөлд хураамжийг даатгагчид хэрхэн шилжүүлэх асуудлыг даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу шилжүүлэх юм. Энэ нөхцөлд Зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчийн хүсэлт, шийдвэрийн дагуу ажиллах учиртай. Мөн зуучлагч нь даатгуулагчид үйлчилгээ үзүүлж буй нөхцөлд даатгагч болон зуучлагч хооронд гэрээ байгуулагдаагүй байх боломжтой. Иймд зөвхөн даатгагчтай байгуулсан гэрээг иш татаж болохгүй.]</p> | <p>Тийм. 7.2.5.даатгагч эсвэл даатгуулагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол бол даатгалын хураамжийг хүлээн авсан даруй даатгагчид шилжүүлэх;</p>  |
| 10. | <p>Төслийн 7.2.7 дахь заалтыг даатгалын зуучлагч нь өөрийн хамтран ажилладаг даатгагчийг тулгахгүй байх, даатгуулагчийн даатгагчаа чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлахгүй байх, тийнхүү агуулга бүхий өөр хэлцэл байгуулахгүй байх, зуучлагчийн санал болгосон даатгалын компанийг сонгохгүй байснаар зуучлагч нь өөр төрийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, бусад байдлаар даатгуулагчид нэмэлт үүрэг үүсгэхгүй байх зэрэг агуулгаар тодруулах хэрэгтэй. Ингэсэн нөхцөлд одоогийн банкууд өөрсдийн хамтардаг даатгалын компания тулгадаг байдлыг халах боломжтой юм. Харин одоо байгаа төслөөр батлагдвал тэр зорилгыг хангаж чадахгүй, бүрэн тодорхой заалт байж чадахааргүй байна.</p>              | <p>Тийм. 7.2.7.даатгуулагчид даатгагчаа чөлөөтэй сонгох боломжийг олгож, эрхийг хязгаарлахгүй байх, даатгалын зуучлагч нь өөрийн хамтран ажилладаг даатгагчийн бүтээгдэхүүн үйлчилгээг тулгахгүй байх</p>   |
| 11. | <p>Төслийн 8.1, 8.2 дахь хэсгээс шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авах гэдэг агуулгыг хасах. [Тайлбар:УИХ, Засгийн газрын зүгээс тусгай зөвшөөрлийн тоог цөөлөх бодлогыг үе үе баримталж ирсэн. Иймд бид тусгай зөвшөөрлийн тоог нэмэх байдлаар төсөл бичих нь тус бодлогод харш юм.</p>  | <p>Үгүй. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах тухай бүрд зөвшөөрлийн асуудал яригдахгүй. Харин хэрэгжүүлж буй арга</p>  |

|     |   |  |
|-----|---|--|
|     | <p>Мөн зуучлагч нь нэгэнт үйл ажиллагаа явуулах тухай тусгай зөвшөөрөл авсан байхад цахимаар борлуулалт хийхийн тулд дахин зөвшөөрөл авах нь өмнөх тусгай зөвшөөрлийг үгүйсгэсэн, хүндрэл, төвөг бий болгосон заалт байна. Учир нь, цахим хэлбэр бол даатгалын зуучлалын л нэг хэлбэр болохоос биш тусдаа үйл ажиллагаа биш. Иймд дахин зөвшөөрөл авах шаардлага байхгүй. Тухайлбал, хуульч нь авсан гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байтал цахимаар хүнд зөвлөгөө өгөхийн тулд дахин шалгарт өгөх, тусгай зөвшөөрөл авах нь утгагүй билээ. Бидний одоо хэрэглэж буй интернет банк, банкны апп-ууд бүгд цахим банкны үйлчилгээ юм. Гэтэл банк энэ болгоны төлөө тусгай зөвшөөрөл гэж явдаггүй шүү дээ. Мөн цахим хэлбэрийн үйл ажиллагааны журмыг Хороо батлах гэдэг ерөнхий байдлаар заах нь төдийлөн зөв биш юм. Харин ерөнхий шаардлагуудыг хуульд заах, Хороо тэрний хүрээнд журам батлаар хуульчлах нь зөв юм. Тэгэхгүй бол 1-т УИХ-ын хууль тогтоох эрх мэдлийг Хороо хязгааргүй байдлаар шилжүүлж авсан хэрэг болно. 2-т эрх зүйн тогтвортой байдал алдагдана. УИХ байн байн хуулиа өөрчлөөд байх нь ховор байдаг. Харин Хороо бол хүссэн үедээ журмаа өөрчлөх боломжтой. Иймд эрх зүйн орчин тогтвортой бус байх эрсдэлтэй болох тул анхаарахыг хүсье.]</p>               | <p>хэрэгслийн нарийн төвөгтэй байдал, онцлог цар хүрээнээс хамааран шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авах гэдэг шаардлагын оронд Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын баталсан Сэндбоксын зохицуулалтын орчинд турших шаардлагыг тавих боломжтой юм.</p>  |
| 12. | <p>Төслийн 9.2.2 дахь заалтыг хасах нь зөв юм. [Тайлбар:Одоо бол хуульд зөвхөн зуучлалын гэдэг нэг л тусгай зөвшөөрөл байгаа. Гэвч Хороо өөрийн журмаар хуульд заагаагүй давхар даатгалын гэдэг тусгай зөвшөөрлийг бий болгосон. Одоо нэмж амьдралын даатгалын гэдэг тусгай зөвшөөрөл бий болгож, зөвшөөрлийн тоог дахин нэгээр нэмэхээр байна. Засгийн бодлого бол тусгай зөвшөөрлийг цөөлөх билээ. Иймд үүний дагуу ажиллах нь зөв байх. Мөн зуучлалын компаниуд томорч чадаагүй өнөөгийн нөхцөлд ингэж олон тусгай зөвшөөрөлтэй болгох нь маш олон жижиг зуучлалын компаниуд бий болгох, зах зээлийн оролцогчид томрохгүй байх үр дагавар бий болгоно. Мөн давхар даатгалын брокер гэдэг бол дотоодын даатгалын зуучлалыг бодоход тусгай, нарийн мэдлэг шаардсан үйл ажиллагаа байдаг. Давхар даатгалын зуучлагч бол ердийн даатгалын зуучлалын үйл ажиллагааг ямар ч асуудалгүй эрхэлдэг. Тодруулбал, ердийн даатгалын зуучлалын сайн компани нь давхар даатгалын зуучлал эрхэлдэг. Иймд давхар даатгалын тусгай зөвшөөрөл авсан нөхцөлд ердийн даатгалын зуучлалын эрх шууд үүсэх байдлаар хуульчлах нь зөв юм. Дагаж мөрдөх журмын тухай хууль батлах, үүнд одоогийн тусгай зөвшөөрөлтэй зуучлалын компаниудын зөвшөөрөл хэрхэн шилжих талаар заах нь зөв юм. Тухайлбал, одоогийн</p> | <p>Үгүй. Манай Монголын нөхцөлд 1 урт хугацааны даатгалын компанийд зориулсан даатгалын зуучлагч компани байгуулах нь хүндрэлтэй тул Даатгалын зуучлалын ангиллыг даатгалын зуучлагч болон давхар даатгалын зуучлагч гэж 2 л ангилан авч үзэх нь зүйтэй.</p> |

|     |   |   |
|-----|---|---|
|     | даатгалын зуучлалын компаниудын тусгай зөвшөөрөл шууд сунгагдах буюу шинээр зөвшөөрөл шаардахгүй талаар заах хэрэгтэй.]   |   |
| 13. | <p>Төслийн 11.1.6 дахь заалтыг хасах саналтай байна. [Тайлбар: Тодорхой бус, хэт ерөнхий заалт байна. Энэ заалт батлагдвал Хороо үзэмжээрээ шийдээд суух боломжтой болох эрдэл үүсэхээр байна. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахын тулд тодорхой, хангалттай үндэслэл байх учиртай билээ. Харин таамаг төдий зүйлээр хүний эрхийг хязгаарлаж болохгүй. Тусгай зөвшөөрөл авна гэдэг бол Үндсэн хуульд заасан аж ахуй эрхлэх эрхээ хэрэгжүүлж буй хэлбэр. Иймд тусгай зөвшөөрөл өгөхөөс татгалзах үндэслэлүүд нь Үндсэн хуульд заасан хүний эрхийг хязгаарлах үндэслэл, зарчмуудад нийцэх учиртай. “Гэж үзвэл” гэж заасан байгааг анхаарна уу. Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргагчид “гэж үзвэл” зөвшөөрөл олгохоос татгалзах бүрэн эрхийг олгосон байна. Үнэхээр нийтийн ашиг сонирхол зөрчигдөх болон хэн нэгэн “гэж үзэх” нь эрс ялгаатай зүйл билээ.]</p>   | Тийм. 11.1.6. тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхээргүй бол.      |
| 14. | <p>Төслийн 11.6 дахь заалттай холбоотой Тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг ажлын 45 хоногт шийдэхээр заасан байна. Энэ нь үндсэндээ 9 долоо хоног буюу ажлын бус өдрөөр 56 хоног байна. Хэрэв дунд нь нийтээр амрах баярын өдөр таарсан нөхцөлд үүнээс ч удахаар байна. Үндсэн хуульд заасан өргөдөл, гомдол шийдвэрлүүлэх эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл хүсэж байгаа. Өргөдөл, гомдлыг бол 30 хоногт шийдвэрлэх, шаардлагатай бол 30 хоног нэг удаад сунгах заалт нэгэнтээ тогтсон билээ. Иймд тэр байдлаар явах нь зөв юм. Тэгэхгүй бол дээр дурдсан хугацаа арай урт байна. Мөн ямар нөхцөлд сунгаж болох талаар ч тодорхой заах хэрэгтэй. Тэгэхгүй бол Монголын 30 хоног нь 50-60 хоног болдог билээ. Иймд ажлын 45 хоног нь 3 сар болох вий дээ гэж эмээж байна.</p> <p>Тухайн улсад бизнес эрхлэхэд хэр амар, хялбар байгаа нь олон улсын хөрөнгө оруулагчдыг татах маш чухал үзүүлэлт болдог. Үүний нэг нь тусгай зөвшөөрөл хэр хурдан шуурхай гарч байна, олгох үйл явц нь хэр ойлгомжтой байна гэдэг асуудал байдаг. Иймд бид тусгай зөвшөөрөл олгох хугацаагаа улам багасгах учиртай болохоос биш холдуулах учиргүй юм.</p> <p>Даатгалын салбарт бизнес эрхлэхийг улам хүндрүүлсээр байвал салбарт хөрөнгө оруулагч орж ирэх нь багасна. Үүний үр дүнд өрсөлдөө хумигдаж, эцэст нь хэрэглэгч хохирох билээ. Зохицуулалт байгаагийн утга учир нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах явдал боловч хөрөнгө оруулагч ихээр орж ирэхгүй, сонирхохгүй бол хэрэглэгч хожим боломжгүйг бодолцохыг хүсье.</p> | Тийм. 11.6.Хороо хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. |

|     |  |  |
|-----|--|--|
| 15. | <p>Төслийн 17.2.2 дахь заалттай холбоотой Хэд хэдэн даатгагчийг төлөөлж ажиллах боломжтой даатгалын төлөөлөгч компани нь даатгалын брокероос ямар ялгаатай вэ? Энэ ялгааг тодруулахгүй бол хэрэглэгч төөрөгдөх, мөн хүмүүс илүү амраар нь даатгалын төлөөлөгчийн эрх аваад бодит байдал дээр брокер мэт үйл ажиллагаа явуулахаар байна. Хэрэглэгчид төөрөгдвэл үүнээс үүдэн даатгалын салбар муу нэртэй болох билээ. Иймд анхнаасаа төөрөгдөл үүсгэхгүй байх үүднээс агент болон брокерын ялгааг маш сайн тодруулж хуульчлах хэрэгтэй юм. Одоо бол хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгч компани болон даатгалын брокер компанийн ялгаа огт алга байна. Үүнийг олон улсад нэгэнт тогтсон хандлагаар нь хуульчлах хэрэгтэй. Магадгүй зөвхөн энэ асуудлын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулбал үр дүнтэй байж магадгүй.</p>  | <p>Үгүй. Хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь 2-3 даатгагчийг төлөөлөн ажиллахаар хязгаарлан журмаар зохицуулах боломжтой.</p>  |
| 16. | <p>Төслийн 21.3-т "... хувь нийлүүлсэн хөрөнгө 21.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд ... мэдэгдэнэ" гэсэн байна. Гэвч төслийн 21.1-д хөрөнгийн хэмжээ заагаагүй байна. Иймд хөрөнгийн хэмжээг тодорхой заана уу. Магадгүй ердийн даатгалын зуучлал болон давхар даатгалын зуучлалын хөрөнгийн хэмжээг ялгаатай байдлаар заах хэрэгтэй байх. Үүн дундаа давхар даатгалын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх нь зөв байх. Учир нь, ердийн даатгалыг бодоход өндөр үнийн дүнтэй даатгалуудад зуучлал хийх билээ.</p> <p>Төслийн 21 дүгээр зүйл нь зөвхөн брокерт хамаарахаар заасан байна. Иймд даатгалын төлөөлөгч компанид хувь нийлүүлсэн хөрөнгийн хязгаарлалт тавигдахгүй гэсэн үг үү? Ингэвэл хүмүүс бүгд даатгалын төлөөлөгч гэсэн компани байгуулах байх шүү. Ижил зах зээлд оролцож буй этгээдүүдэд ийм ялгамжтай байдлаар хандаж болохгүй билээ. Зөвхөн даатгагчийг төлөөлж, түүнд үйлчилгээ үзүүлж байгаа болохоос биш ялгаагүй зуучлалтай ижил хариуцлага хүлээх этгээд билээ. Иймд даатгалын төлөөлөгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхой заах хэрэгтэй.</p> <p>Төслийн 21.1-т зөвхөн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх талаар заасан байна. Энэ нь хэр зөв вэ? Хөрөнгө оруулагч нь өөрөө үл хөдлөх эд хөрөнгөтэй буюу оффистой, түүнийгээ компанийн үйл ажиллагаанд ашиглах гэж байгаа нэхцэлд оффисоор хөрөнгө оруулалт хийж яагаад болохгүй гэж. Зөв нь бол хуулиар шаардсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг заавал мөнгөн хэлбэрээр бүрдүүлэх, үүнээс давсан хөрөнгө оруулалтыг харин мөнгөн бус хэлбэрээр ч хийх боломжтой байх нь зөв билээ. Мөн хувь нийлүүлсэн хөрөнгө нь мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө оруулалтаас бүрдэх</p> | <p>Үгүй. Хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгчдөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ тавих шаардлагагүй, харин мэргэжлийн хариуцлагын даатгалын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх нь зүйтэй байна.</p> |

|     |   |   |
|-----|---|---|
|     | нөхцөлд мөнгөн хөрөнгө оруулалтын дүн нь хуульд заасан хэмжээнээс буурахгүй байхыг шаардсанаар хууль тогтоогчийн шаардлага хангдах боломжтой юм.  |   |
| 17. | Төслийн 22.2 дахь заалттай холбоотой Төслийн 22.1-т шаардлагатай зохицуулалтыг хийж өгсөн байна. Гэтэл яагаад Хороо хүсвэл өөр юм шаардаж болно гэж заах ёстой вэ? Ялгаагүй Хороонд үзэмжээр шийдвэр гаргах эрх олгосон заалт тул хууль тогтоох эрх мэдлийг УИХ-д хадгалах, хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчим зөрчигдөхөөр байна. Тухайлбал, А гэдэг компанийд Хороо илүү шаардлага тавиад, Б гэдэг компанийд тэр шаардлагаа тавихгүй байх эрхтэй болох нь. Энэ бол дур зорго, үзэмж билээ. Үүний үр дүнд хүнд суртал, дур зорго, хахууль, авлигат бий болох, хүний эрх зөрчигдөх эрсдэлтэй юм.   | Тийм. Хувьцаа шилжүүлэхэд тавигдах шаардлагыг 22.1-т тодорхой зааж өгсөн тул 22.2 дахь заалтыг хасах  |
| 18. | Төслийн 28.3 дахь заалттай холбоотойгоор Даатгалын төлөөлөгч нь зөвхөн иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээ зуучлах зохицуулалт нь хэд хэдэн компани төлөөлөх даатгагчид мөн адил хамааралтай юу?  | Тийм. Ижил хамааралтай.   |
| 19. | Төслийн 29.1 дэх заалттай холбоотойгоор Даатгалын зуучлагчийн үйлчлүүлэгч нь даатгуулагч байх боломжтой. Энэ нөхцөлд хураамжийг хэрхэн шилжүүлэх талаар даатгуулагч нь зуучлагчдаа чиглэл, заавар өгөх эрхтэй. Зуучлагч бол өөрийн үйлчлүүлэгчийн зааврыг л дагах, биелүүлэх ёс зүйн үүрэгтэй болно. Гэтэл төслийн 29.1.1-т хураамжийг өөртөө хүлээн авах гэх мэт үйлдэл хийхийн тулд даатгагчаас зөвшөөрөл авахыг шаардаж. Хураамж нь даатгагчид төлөгдөх хүртэл даатгуулагчийн өмч тул түүнийг хэрхэн захиран зарцуулах эрх нь даатгуулагчид хадгалагдана. Иймд даатгагчид шилжээгүй хураамжийн талаар даатгагчаас зөвшөөрөл авахыг шаардах нь утгагүй. Иймд төслийн 29.11 дэх заалтыг “даатгалын зуучлагчийн үйлчлүүлэгч зөвшөөрсөн” гэж өөрчлөх нь зүйтэй юм. Хэрэв зуучлагч нь даатгагчийг төлөөлж байвал даатгагч, даатгуулагчийг төлөөлж, үйлчилгээ үзүүлж байвал даатгуулагчийн зөвшөөрлөөр хийнэ гэсэн үг. | Тийм. 29.1.1.даатгалын хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг даатгалын зуучлагчийн үйлчлүүлэгч зөвшөөрсөн;  |
| 20. | Төслийн 29.2 дахь заалтыг хасах нь зөв гэсэн зарчмын, хатуу байр суурьтай байна. Бид зах зээлийн эдийн засагтай, Ардчилсан улс гэдгийг Үндсэн хуулиар тунхагласан. Иймд Төр аливаа бүтээгдэхүүний үнийг тогтоох учиргүй. Энэ бол Социалист нийгэм, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн ойлголт юм. Гэтэл Хороо хүсвэл зуучлалын үйл ажиллагааны хөлс буюу үнийг тогтоож болохоор хуульд заасан байна. Энэ бол байж болохгүй зүйл юм. Хороо нэгэнтээ бизнес хийхгүй, хөрөнгө оруулагчийн бизнесийн эрсдэлийг үүрэхгүй учир яагаад түүний өмнөөс үнэ тогтооно гэж. Энэ бол  | Үгүй. ДТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай |

|     |   |   |
|-----|---|---|
|     | <p>Эдийн засгийн хувьд аль хэдийн шийдэгдсэн зүйл билээ. Та бүхэн чөлөөл эдийн засгийн ойлголтоос ухарч байгаа гэдгээ ойлгож байна уу? Эсвэл гаднын хөгжсөн улсууд бас ингэж үнэ тогтоодог юм аа гэж хэлэх юм уу? Энэ заалтыг хасна уу.</p>   | <p>холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох төрийн захирагааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулна.", 8.2-т "Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг даатгагч тогтооно." гэж тус тус заасан. Хороо зөвхөн шаардлагатай тохиолдолд даатгалын хураамжийн тооцооллын нэг хэсэг болох даатгалын гэрээний зардал буюу даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тооцоолох боломжийг байлгах үүднээс тус саналыг хүлээн авах боломжгүй.</p> |
| 21. | <p>Төслийн 31.1-т ёс зүйн дүрмийг мэргэжлийн холбоо тогтоохоор заасан байна. Гэтэл нэгдсэн нэг холбоотой байх талаар хуульд заагаагүй. Иймд хэдэн ч холбоо байж болох нь байна. Энэ нөхцөлд зуучлагч бүр зөвхөн өөрийн Холбооны ёс зүйн дүрмээ дагах ёстой болох нь. Энэ бол дабль стандартыг бий болгоно. Мөн хэрэглэгчийг төөрөгдүүлнэ. Бид хуульчаас үйлчилгээ аваходаа "миний нууцлалыг хадгална" зэрэг нэг л стандарт, ёс зүйн шаардлага байгаа гэдэг ойлголт, хүлээлттэй байдаг. Гэтэл даатгууллагч зуучлалын компаниас үйлчилгээ аваходаа танайх аль холбоонд хамаардаг вэ? Тэр нь ямар ёс зүйн журамтай вэ зэргээр тодруулж явах ёстой юм уу? Тийм үр дагавар бий болгох нь байна. Ёс зүйн стандарт нэг байх нөхцөлийг хангах учиртайг анхаарна уу. Мөн мэргэжлийн холбоонд хуулиар бүрэн эрх шилжүүлж байгаа бол ямар холбоо болохыг тодорхой заана уу.</p> <p>Мөн зуучлагчийн дагаж мөрдөх ёс зүйн журам гаргах талаар заасан нь брокер болон төлөөлөгчид нэгэн адил хамаарахаар байна. Гэтэл Төлөөлөгч болон зуучлагчид өөр өөр ёс зүйн шаардлага тавигддаг билээ. Үүнийг яаж нэгтгээд батлах юм бэ? Төлөөлөгч болон зуучлагчийн ёс зүйн дүрмийг нэг байгууллага батлах нөхцөлд төлөөлөгч болон зуучлалын үйл ажиллагааны ялгаа зааг улам бүдгэрэх эрсдэлтэй болно. Иймд зуучлагч болон төлөөлөгчид ёс зүйн журмаа тус тусдаа батлах, тус тусдаа үйл</p> | <p>Үгүй. Даатгалын тухай хуулийн төслийн 23.2.2-т Даатгалын мэргэжлийн холбооны эрхлэх үйл ажиллагааны чиглэлд хамаарах зохицуулалттай этгээдийн тавиас дээш хувийг гишүүнээр элсүүлсэн байх шаардлагыг тавьсан байгаа тул тухайн асуудлын хүрээнд 1 л холбоо байх боломжтой юм. Харин 1 зохицуулалттай 1 л мэргэжлийн холбоонд багтсан шаардлагыг оруулах нь зүйтэй байна.</p>   |

|     |  |   |
|-----|--|---|
|     | ажиллагаа явуулах нь зүйтэй юм.  |   |
| 22. | <p>Төслийн 35.1.8 дахь заалтыг хасах саналтай байна. Учир нь, энэ нь Хорооны хяналт шалгалтын эсрэг үзэл бодлоо илэрхийлэх, өөрийн үзэл бодлоо нийтэд түгээх эрх чөлөөг хязгаарласан агуулгатай байна. Хүн заавал үнэн, зөв мэдээ тараах ёстой, үүрэгтэй ч гэж үздэггүй. Энэ бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар олон улсад тогтсон ойлголт билээ. Яагаад гэвэл үзэл бодол гэдэг бол үнэн, зөв гэж батлах, нотлох боломжгүй ч зүйл байдаг. Гэтэл хуульд шалгалт хийж буй этгээдийн эсрэг юм хэлэхгүй, нотолгоогүй мэдээ тараахгүй зэргээр “бид шалгаж байхад та нар дуугүй байх ёстой шүү” гэсэн маш ноцтой заалт оруулсан байна. Төрийн хяналт шалгалт нь төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр тул төрийг шүүмжлэх, түүний талаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ялгаагүй хэрэгжих учиртай билээ.</p> <p>Шалгалтын үргэлжлэх хугацааны хязгаарыг заанаа уу. Жишээ нь жилийн 365 хоногийн турш үргэлжлэх шалгалт хийж болохгүй. Ингэвэл бизнесээ хийх биш Хороонд л тайлагнадаг ажилтай болно. Ингэж байхаар бизнесээ хаасан нь ашигтай болно биз. Гэтэл энд хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа байхгүй, хүсвэл хэдий ч хугацаагаар шалгаад байж болохоор заасан байна. Хяналт шалгалтын тухай урьдчилж мэдэгдэх, яагаад шалгах болсон үндэслэлээ танилцуулах, тайлбарлах, хяналт шалгалтын хүрээ, хязгаар, удирдамжийг танилцуулах зэргээр шалгуулж буй этгээдийг мэдээллээр хангасан, шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулсан зохицуулалт хэрэгтэй юм. Хяналт шалгалт яригдаж буй нөхцөлд нэг талд нь шалгалтад хамрагдаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх нь чухал байдаг. Цагдаа ирээд мэдүүлэг авахаар болсон үед мэдүүлэг авахаар бичгээр дуудах, яагаад мэдүүлэг авч байгааг хэлэх, ямар эрх, үүрэгтэй болохыг тайлбарлах зэргээр мэдээлэл өгөх, эрх, үүргийг нь тайлбарлах зэргээр шийдвэр гаргах ажиллагааны журам баримталдаг билээ. Гэтэл төсөлд зөвхөн Хороо хяналт шалгалтаа саадгүй явуулах талаас нь л бодож бичсэн байна.</p> | Үгүй. Даатгалын зах зээлд оролцогч талуудын эрх ашиг тэгш хамгаалагдсан байх учиртай. Гэтэл ажлаа хийж буй ажилтны эрх ашгийг зөрчиж болохгүй.  |
| 23. | <p>Төслийн 37 дугаар зүйл нь мөн адил хяналт шалгалтад хамрагдаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалт алга. Тухайлбал, зөвхөн тухайн этгээдэд байгаа мэдээллийг шаардах, мэдээлэл, баримт гаргаж өгөх боломжит хугацаа олгох, шаардаж буй баримтад тодорхой нэрлэн заах, мэдээллийн боловсруулалтыг Хороо өөрөө хийх зэрэг асуудлыг заах хэрэгтэй. Тухайлбал, мэдээлэл шаардаж байна гэдэг нэрийдлээр Хороо мэдээлэлд өөрсдөө анализ, дүгнэлт хийхийн оронд</p>  | Үгүй. Төслийн 37 дугаар зүйлд тодорхой төрлийн болон тусгайлсан мэдээлэл, баримт бичиг авах боломжтой талаар тодорхой дурдсан байх бөгөөд эдгээр мэдээлэл, баримт бичгийг авах "боломжит" хугацаа гэх тодорхойгүй |

|     |   |  |
|-----|---|--|
|     | анализ хийсэн мэдээлэл гаргаж өгөхийг шаардвал өөрийн хийх ажлаа бусдаар хийлгэсэн хэрэг болно. Мөн ерөнхий, тодорхой бус байдлаар мэдээлэл шаардвал ойлгомжгүй байдал үүснэ. Дараа нь шаардсан мэдээлэл өгөөгүй гэж дарамтлах асуудал үүсэх эрсдэлтэй. Ер нь төрөөс гаргаж буй шийдвэр бүр тодорхой байх ёстой байдаг. Гэтэл энд зах хязгааргүй Хороо хүсвэл түүнийг нь биелүүл гэсэн зохицуулалт л байна. Төслийн 37.2-т “мэдээлэл, баримт гаргаж өгөх хугацааг Хороо заана” гэж заасан боловч боломжит хугацаа байх гэх мэт зүйл алга.   | зүйлийг хуульд оруулах нь тохиромжгүй юм.  |
| 24. | Төслийн 39.1.2-т “хохирол учруулахуйц” гэснийг “хохирол учруулсан” гэж заах. Тэгэхгүй бол хараахан хохирол учраагүй байгаа ч учруулахуйц болжээ гэж үзэж албадлага хэрэглээд байвал үзэмж, дур зоргын асуудал болно. Учруулахуйц гэдэг бол тодорхой бус, хүний үзэмжээр шийдвэрлэгдэхээр асуудал болох билээ.   | Үгүй. Олон улсад эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг. Тухайн үйлдэл гарсны дараах уламжлалт аргаас илүү эрсдэл гарахаас нь өмнө урьдчилан анхааруулах систем үйлчлээд удаж байна.  |
| 25. | Төслийн 39.1.3-т “болзошгүй гэж үзвэл” гэдгийг хасна уу. Мөн адил үзэмж байна. Төлбөрийн чадваргүй болоогүй гэхдээ би болзошгүй гэж үзлээ гээд албадлага хэрэглээд байх эрхийг Хороонд олгосон заалт байна.   | Тийм. 39.1.3.төлбөрийн чадваргүй болсон бол;   |
| 26. | 39.1.7-д “удаа дараа” эсвэл “санаатайгаар” гэж нэмэх. Тэгэхгүй бол мэдээлэл явуулахдаа нэг алдаа гаргасан байхад л албадлага хэрэглэх үндэслэл болохоор байна. Тухайлбал, нэг үсэг алдаж бичих, хүний нэр буруу бичих, тоог 1, 2-р зөрүүлж алдаатай бичсэн ч “Хороонд бодитой бус мэдээлэл өгсөн” гэх үндэслэлд хамаарахаар байна. Албадлага хэрэглэх буюу хүний эрх, эрх чөлөөг зөрчих үндэслэл ийм ерөнхий, энгийн байж болохгүй билээ.   | Үгүй. Төөрөгдүүлсэн мэдээллийн шинж чанар, үр дагавар ноцтой эсэхээс хамаарч албадлагын арга хэмжээ авах эрхийг Хороо хэрэгжүүлэх нь зүйтэй юм.  |
| 27. | Төслийн 39.1.6-д тохиромжтой бус этгээд гэж үзсэн бол албадлага хэрэглэхээр заасан байна. Гэтэл энэ нөхцөлд түүнийг арилгах хугацаа өгөөд, түүнийг арилгах арга хэмжээ аваагүй бол арга хэмжээ авахгүй юм уу? Мөн хувьцаа эзэмшигч нь тохиромжтой бус этгээд боллоо гэхэд тэр нь яагаад шууд компанийд арга хэмжээ авах үндэслэл болно гэж. Үндсэн хуульд ял зэмлэлийг бусдад халдаахгүй байх зарчим хуульчлагдсан. Иймд хувьцаа эзэмшигч гэж хүний гэм бурууг яагаад компанийд халдаана гэж. Компанийн 15 хувийн хувьцаа эзэмшиж буй этгээд тохиромжтой бус этгээд боллоо гэхэд компани яах вэ? Тэр хүний хувьцааг шууд хураан авах эрх байхгүй шүү дээ. Яагаад гэвэл тэр хүний өмч байдаг. Иймд компанийд арга хэмжээ авна гэдэг бол бараг “та нар наад хүний хувьцааг хураан авах ёстой байсан” гэх утга биш гэж үү? | Үгүй. 1-р асуудлын тухайд:<br>Компанийн тухай хуулийн<br>9.3.Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.<br><br>9.4.Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл |

|     |  |  |
|-----|--|--|
|     |  | <p>ажиллагааны улмаас компанийд учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.</p> <p>9.5.Хувьцаа эзэмшигчийн компанийд оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна. гэж тус тус заасан байдаг бөгөөд тухайн нөхцөл байдлаас хамааруулан хувьцаа эзэмшигч дангаар хариуцлага хүлээх нь үү эсхүл компани нь хариуцлага хүлээх нь үү гэдгийг хяналт шалгалтын явцад энэхүү хуулийн зүйл заалтаар тодорхойлон шийдвэрлэх боломжтой байна.</p> |
| 28. | <p>Төслийн 41.7 дахь заалттай холбоотойгоор Нэгэнт тусгай зөвшөөрлийг хугацаатай түдгэлзүүлсэн бол тус хугацаа дуусах үед Хороо эрх сэргээх гэдэг шийдвэр гаргах шаардлагагүй юм. Тэгэхгүй бол дахиад л хүнд суртал, төвөг болохоор байна. Жишээ нь, түдгэлзүүлсэн хугацаа нь 2022.9.15-ны өдөр дууслаа гэж үзье. Энэ үед хугацаа нь болоод нөгөө этгээд нь “манай эрхийг сэргээж өгнө үү” гэж хүсэлт өгөх нь байна. Хороо тэрийг шийдэх гэж хуралдах гэж дахиад 1 сар болбол тэр үед тусгай зөвшөөрөл эзэмшигч давхар шийтгэгдэж, хохирох нь байна. Иймд юуны тулд хугацаатай түдгэлзүүлж байгаа билээ, анх түдгэлзүүлэхдээ тус шийдвэрийн дуусах хугацааг зааж, тус хугацаа дууссанаар тусгай зөвшөөрөл шууд сэргэдэг байхаар зохицуулах нь зөв юм.</p> <p>Төслийн 42.1.5-д мөн адил тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөлд сэргээлгэх талаар хүсэлт ирүүлэх тухай заасан байна. Иймд бидний дээр дурдсан жишээ яг болох юм байна. Зөв нь, ямар ч хүсэлт, шийдвэр болохгүйгээр түдгэлзүүлсэн хугацаа дуусах үед тусгай зөвшөөрөл шууд сэргэх явдал юм.</p> | Тийм. Саналыг хаав.  |

|     |   |  |
|-----|---|--|
|     | Харин Хорооноос нөхцөл, шаардлага тавьж түдгэлзүүлсэн бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түүнийг биелүүлсэн талаар баримт, хүсэлт ирүүлж байж эрхээ сэргээлгэх нь тодорхой.   |  |
| 29. | Төслийн 44.1 дэх заалттай холбоотойгоор Даалгаврыг албан бичгээр ч өгч болохоор зааж. Үүнийг хасна уу. Хороо нэг албан бичиг ирүүлж, харьцаж байснаа дараа нь Даалгавар байсан шүү гэх боломжтой юм байна. Ер нь Хороо хуульд заасан ямар нэгэн шийдвэр гаргаж байгаа бол энэ нь хуулийн аль хэсэгт заасан, ямар агуулгатай шийдвэр болох талаар хуульд заах хэрэгтэй юм. Тэгэхгүй бол түүнийг хүлээж авч буй этгээд түүний үр дагаврыг ойлгохгүй, хохирох эрсдэлтэй болно.   | Тийм. 44.1.Хороо даатгалын зуучлагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараах агуулга бүхий даалгаврыг улсын байцаагчийн албан шаардлагаар өгч болно:  |
| 30. | Төслийн 44.1.5 дахь заалтыг хасах. Тодорхой бус, ерөнхий байдлаар Хороонд эрх олгосон байна. Энэ заалт байгаа нөхцөлд Хороо юу ч гэж даалгавар өгөхөөр байна. Тухайлбал, наад ажилтнаа ажлаас хал, цалингаа нэм, хас гэсэн ч болохоор юм байна. Ийм ерөнхий заалт яагаад байж болохгүй тухай дээр хангалттай тайлбарласан гэж бодож байна. Мөн даатгалын зуучлагчийн хувьд өөрийн үйлчлүүлэгчийн эрх ашгийг л хамгаална. Иймд даатгуулагчид үйлчилгээ үзүүлж байгаа нөхцөлд даатгагчийн эрх ашгийн төлөө ажиллах үүрэг хүлээхгүй билээ. Иймд яагаад даатгагчийн эрх ашиг ярьж зуучлагчид даалгавар өгнө гэж. Тухайлбал, зуучлалын хөлсөө багасга, тэгэхгүй бол даатгагчийн эрх зөрчигдөөд байна гэх юм уу? Энэ заалт бол их байж боломгүй санагдаж байна. | Тийм. Саналыг хасав.   |
| 31. | Төслийн 46.2.2-т хороо шаардсан бол мэдээллийн нууцлалыг задруулж болох талаар заасан байна. Энэ нөхцөлд Хороо хүсвэл нэг нэгэн этгээд, аль нэг зуучлагчийн нууцлалыг задруулаад суух нь байна. Энэ нь Хорооны бүрэн эрх учир ямар ч хариуцлага хүлээхгүй юм байна. Энэ нь Мэдээллийн нууцлалыг хадгалах тухай манай бусад хуулиудад нийцэхгүй байна. Сүүлд батлагдсан хуулиудаа уншиж судлахыг хүсье. Төрийн хяналт шалгالت ч гэсэн нууцыг хадгалах, эрүүгийн гэмт хэрэг шалгах ажиллагаа ч нууцлалыг хадгалах үүрэгтэй байдаг.  | Тийм. Саналыг хасав.   |
| 32. | Төслийн 46.2.3-т “байгууллагын удирдлага хүсэлт гаргавал” нууцлал задруулах талаар заасан байна. Зөв нь тэдгээр байгууллагуудад хуулиар эрх олгогдсон нөхцөлд тэдгээр байгууллагуудад мэдээлэл өгөх юм. Өөрөөр хэлбэл, цагдаа бид шалгаж байна ийм ийм мэдээлэл ирүүл гэвэл тэрийг өгч болно. Тэрнээс зүгээр тэд “хүсэхэд” мэдээлэл өгдөг байж болохгүй билээ. Төслийн заалт бол “хүсэлт” ирсэн байхад л хууль харахгүйгээр, хуулийн үндэслэл шаардахгүйгээр нууцлал задруулахаар байна шүү.  | Үгүй. Хуулийн төслийн 46.2.3-т заасан заалт нь ажлын шаардлагаар ирүүлсэн хүсэлт гэж байгаа болно. Ажлын шаардлагаар гэдэг нь шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуульд заасан эрх үүргээ хэрэгжүүлэх ажил гэж |

|  |   |  |
|--|---|--|
|  |   | оилгох тухайн заалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй болно.   |
| 33.  | Төслийн 46.2.5 дахь заалтаас “мэдэх боломжтой” гэдгийг хасна уу. Учир нь, үзэмжийн заалт байна. Мэдэх боломжтой, угүй эсэхийг яаж тогтоох юм? Хороо мэдээлэл задруулчхаад дараа нь “Иргэд мэдэх л байсан шүү дээ” гэж суух юм уу? Ийм дур зорго, таамаг байдлаар шийдвэр гарч болохгүй шүү дээ. Хүний эрхийг хөндөх, зөрчихийн тулд тодорхой факт, нотолгоо хэрэгтэй. Тэрнээс хэн нэгний “боломжтой” гэх мэт үзэмжээр шийдвэр гаргаж, хүний эрхийг зөрчиж болохгүй.   | Үгүй. Хуулийн төсөлд заасан уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой гэдэг нь иргэн хуулийн этгээдийн мэдэх боломж бүхий эрхийг хэлж байна. Таны ирүүлсэн саналд “…Мэдэх боломжтой, угүй эсэхийг яаж тогтоох юм” гэсэн байна. Жишээ нь Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сонин сэтгүүл гэх мэтэд нийтлэгдсэн мэдээлэл байвал түүнийг мэдэх боломжтой гэж хэлж болох юм.                     |
| 34.  | Төслийн 50 дугаар зүйлтэй холбоотойгоор Үндсэн хууль шударга ёсны зарчим нь тэрийн үйл ажиллагааны зарчим болох талаар заасан. Хэн нэгэн хууль зөрчсөн бол түүний төлөө зохих, хуульд заасан хариуцлага хүлээх нь шударга ёсны зарчим юм. Иргэн А цагдааг зодвол түүний төлөө хариуцлага хүлээх учиртай. Цагдаа ч иргэн А-г зодвол хариуцлага хүлээх учиртай. Тэрнээс би цагдаа юм чинь хариуцлага хүлээхгүй гэж хэлэх нь Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй. Гэтэл Хороо болохоор “бид хариуцлага хүлээхгүй” гэх нь байна. Манайд Хорооноос бусад, даатгалын хуулиудаас бусад хаана ч ийм заалт байдаггүй юм шүү. Иймд үүнийг Зуучлалын хууль болон Даатгалын тухай хуулийн төслөөс хасахыг хүсье. | Үгүй. Хуулийн төсөлд тусгах боломжгүй. Учир нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд тодорхой тусгагдсан.  |
| <b>V. Сангийн яамны сайтаар олон нийтийн хэлэлцүүлэгт ирсэн саналууд</b> |   |  |
| 1.   | Ц.Будмаа: Уг хуулийн зорилго хэсэгт даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасах гэж тодорхойлсон боловч төсөлд төлөөлөгчид Хорооноос эрх олгох тухай заалтууд байсаар байна. Мөн, Даатгалын зуучлагчийн мэргэшсэн байдлыг нэмэгдүүлэх зохицуулалтууд тусгана гэсэн боловч үүнтэй холбоотой зохицуулалтууд төсөлд тусгагдаагүй. Давхар даатгалын зуучлалын зохицуулалтыг тусгана гэсэн боловч тусгагдаагүй.   | Үгүй. Даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийг төлөөлөхийн тулд даатгагчаас олгосон зөвшөөрлөөс гадна Хорооноос тусгай зөвшөөрөл авч байгаа нь төрд ачаалал үүсгэсэн, даатгалын төлөөлөгчид чирэгдэл учруулсан ач холбогдолгүй зохицуулалт байгаа тул олон улсын туршилагад нийцүүлэн даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл авах заалтыг хасаж Хорооноос эрх авдаг байхаар зохицуулсан. Эрх авах нь тавигдах |

|    |   |  |
|----|---|--|
|    |   | шаардлага багатай, цаг хугацаа хэмнэсэн, шат дамжлага бага зэрэг ач холбогдолтой. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг илүү мэргэшсэн, төрөлжүүлсэн байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд даатгалын брокерын үйл ажиллагааг ердийн даатгалын брокер, амьдралын даатгалын брокер, давхар даатгалын брокер гэж 3 ангилсан нь холбогдох журам заавраар тавигдах шаардлагыг зохицулахаар болсон. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, буртгэлийн шаардлагууд бүгд ялгаатай төдийгүй, шат дамжлагын хувьд ч төдийгүй шийдвэрлэх хугацаа өөр.  |
| 2. | Ц.Будмаа: Хуулийн төслийн 29.2 заалтад Даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг СЗХ тогтоож болно гэсэн нь Даатгалын брокер гэсэн аж ахуйн нэгжийн өнцгөөс харвал үйлчилгээний орлогын хэмжээг төрөөс хязгаарлах боломжийг нээж өгсөн буруу алхам юм. Сайн дурын даатгалыг иргэд эсвэл байгууллагуудад зуучлах бизнес рүү орж буй мэргэжлийн компани өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн хязгаарыг СЗХ-оор тогтоолгох нь уг секторт төрийн хязгаарлалттай шаардлагагүй оролцоог нэмэгдүүлж байна. Зах зээлийн өрсөлдөөнт орчинд компани бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ үнэ тогтоолтыг зах зээлийн өрсөлдөөний журмаар тогтоодог, хэт өндөр тогтоосон нь даатгагчтай хамтарч ажиллаж чадахгүй гэсэн өрсөлдөөний зарчмаар үнэ тогтох нь зүйтэй. Нөгөө талаас даатгагчид аль хэдийн зуучлагчдын шимтгэлийн хэмжээг бууруулж эхэлсэн. Зуучлалын зах зээлд монопол тогтсон зүйл байхгүй бөгөөд энэ заалтыг зах зээлийг гажуудуулах аюултай гэж үзэж байна. | Үгүй. ДТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамtran баталсан журмаар нарийвчлан зохицуулна.", 8.2-т "Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг даатгагч тогтооно." гэж тус тус заасан. Хороо зөвхөн шаардлагатай тохиолдолд даатгалын хураамжийн тооцооллын нэг хэсэг болох даатгалын гэрээний зардал буюу даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тооцоолох боломжийг байлгах |

|    |   |  |
|----|---|--|
|    |   | үүднээс тус саналыг хүлээн авах боломжгүй.   |
| 3. | Ц.Будмаа: 39.1.10 заалтад 32,4-т заасны дагуу гэж дурдсан ба ийм заалт уг хуулийн төсөлд байхгүй байна.   | Тийм. Сангийн яам өөрчлөлт хийхдээ холбогдон өөрчлөгдөх заалтыг өөрчлөгдүүгүй байна.   |
| 4. | Т.Лхагвацэрэн: 3.2-т: "Даатгалын брокерын салбар", "Даатгалын брокерын төлөөлөгчийн газар" гэсэн нэр томьёог нэмэх. /Брокерын салбар болон төлөөлөгчийн газрын ялгааг тодорхойлоод үйл ажиллагааных нь чиглэл, статусыг тодорхойлох, тавигдах нөхцөл шаардлагыг мөн ялгаатайгаар оруулах саналтай байна./   | Үгүй. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд Компанийн салбар, төлөөлөгчийн газрын зохицуулалтыг тодорхой заасан байдаг тул уг заалтын дахин ДЗТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах шаардлагагүй тул саналыг тусгахгүй.   |
| 5. | Т.Лхагвацэрэн: 29.2-т: "Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно." гэснийг "Хороо албан журмын даатгалын даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно" гэж өөрчлөх. /Хэрэв даатгагч, даатгалын зуучлагчийн хамтын ажиллагааны гэрээгээр зохицуулагддаг борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн харилцаанд Хорооны зүгээс зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байгаа бол зөвхөн албан журмын даатгалын хувьд оролцдог байх нь зүйтэй гэсэн саналтай байна./ | Үгүй. ДТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогdon үүсэх харилцааг Хороо, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулна.", 8.2-т "Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг даатгагч тогтооно." гэж тус тус заасан. Хороо зөвхөн шаардлагатай тохиолдолд даатгалын хураамжийн тооцооллын нэг хэсэг болох даатгалын гэрээний зардал буюу даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тооцоолох боломжийг байлгах үүдээс тус саналыг хүлээн авах боломжгүй. |

---Ооо---